

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА
НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны дугаар сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.23 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.“Цар тахлын үед Засгийн газар, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга /цагдаагийн хурандаа Р.Отгонжаргал/, Харилцаа холбооны зохицуулах хорооны Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга /З.Эрдэнэчулуун/-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга /цагдаагийн хурандаа Ц.Ням-Очир/, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нарт тус тус даалгасугай.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

Ж.БОЛД

Г.ЧИНЗОРИГ

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Харилцаа холбооны зохицуулах
хорооны дарга нарын 2021 оны
дүгээр сарын өдрийн
дугаар хамтарсан тушаалын хавсралт

ЦАР ТАХЛЫН ҮЕД ЗАСГИЙН ГАЗАР, ТӨРИЙН БУСАД БАЙГУУЛЛАГА,
АЖ АХУЙН НЭГЖТЭЙ ЦАР ТАХЛЫН ХҮРЭЭГ ТОГТООХТОЙ ХОЛБООТОЙ
ТООН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙГ ШУУРХАЙ СОЛИЛЦОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал /цаашид “цар тахал” гэх/-ын үед Засгийн газар, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгж /цаашид “төрийн болон бусад байгууллага” гэх/-тэй цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох, сан бүрдүүлэх, ашиглах харилцааг зохицуулахад оршино.

1.2.Төрийн болон бусад байгууллагатай цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох харилцаанд Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмаас гадна дор дурдсан зарчмыг баримтална:

1.2.1.хууль дээдлэх, хүний эрх чөлөөг хүндэтгэх;

1.2.2.нууцыг чанд хадгалах;

1.2.3.олон нийтийн итгэл хүндлэл, дэмжлэг авах;

1.2.4.тоон мэдээ, мэдээллийг хуульд зааснаас бусад зорилгоор ашиглахгүй байх;

1.2.5.шуурхай, үнэн бодит байх.

1.3.Энэхүү журмыг Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаанд дагаж мөрдөнө.

Хоёр.Тоон мэдээ, мэдээллийн санг бүрдүүлэх

2.1.Олон төрлийн мэдээ, мэдээллийн систем болон мэдээллийн сангийн эх үүсвэртэй холбогдон ажиллах чадвартай, нийтийн түлхүүрийн дэд бүтэцтэй холбогдсон, байгууллага хооронд цахим мэдээлэл солилцох зориулалт бүхий, хадгалалт, аюулгүй байдлыг хангасан, Улсын онцгой комисст байрших мэдээлэл солилцох систем байна.

2.2.Харилцаа, холбооны зохицуулах хороо нь тоон мэдээ, мэдээллийн системийг холбогдох хууль тогтоомж, төрийн болон бусад байгууллагаас тогтоосон журмын дагуу бүрдүүлнэ.

2.3.Төрийн болон бусад байгууллага энэ журмын 2.2-т заасны дагуу бүрдүүлсэн мэдээллийн сангийн тоон мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцаж, мэдээллийг тогтоосон хугацаанд шинэчилж байна.

Гурав.Тоон мэдээ, мэдээллийг ашиглах, солилцох

3.1.Төрийн болон бусад байгууллагын тоон мэдээ, мэдээллийг цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг төлөвлөх, авах, олон нийтэд мэдээлэх зорилгоор ашиглана.

3.2.Төрийн болон бусад байгууллагатай тоон мэдээ, мэдээлэл солилцоход хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл солилцох системээр дамжуулна.

3.3.Онцгой комисс нь төрийн болон бусад байгууллагаас авсан тоон мэдээ, мэдээллийг ашиглах, солилцох талаар хамтран ажиллана.

Дөрөв.Тоон мэдээ, мэдээлэл солилцох системд холбогдох талуудын үүрэг

4.1.Харилцаа холбооны зохицуулах хороо дараахь үүрэгтэй:

4.1.1.тоон мэдээ, мэдээлэл солилцох системийн ашиглалтын бэлэн байдал, хөгжүүлэлт, тогтвортой ажиллагааг хариуцан зохион байгуулах;

4.1.2.мэдээлэл солилцох системээр дамжих цахим мэдээллийн нууцлал, цахим мэдээлэл солилцох ажиллагааны нууцлал, аюулгүй байдлын нэгдсэн шаардлагыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.3.мэдээлэл солилцох системийн мэдээлэл авсан түүхчилсэн бичлэг хөтлөх, статистик мэдээ гаргах, холбогдох талуудыг мэдээллээр хангах;

4.1.4.мэдээлэл солилцох, ашиглах талаар төрийн болон бусад байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

4.1.5.мэдээллийн сан, системийн аюулгүй байдлын талаар энэ журмын 4.1.2-т заасан шаардлагын дагуу зааварчилгаа өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.6.мэдээлэл солилцох систем дэх төрийн болон бусад байгууллагын цахим мэдээллийн нэр төрөл, тодорхойлолтыг мэдээлэх, түүний хэрэглээг нэмэгдүүлэх, сурталчлах;

4.1.7.мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцах.

4.2.Цагдаагийн байгууллага дараахь үүрэгтэй:

4.2.1.худал тоон мэдээ, мэдээлэл түгээсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу шалган шийдвэрлэх;

4.2.2.эрх бүхий албан тушаалтан, байгууллагад шаардлагатай тохиолдолд танилцуулга, санал, хүсэлт хүргүүлэх;

4.2.3.цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой онцлог тоон мэдээ, мэдээллийг яаралтай солилцох;

4.2.4.худал тоон мэдээ, мэдээлэл түгээх, иргэдийг төөрөгдүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах.

4.3.Төрийн болон бусад байгууллага дараахь үүрэгтэй:

4.3.1.мэдээллийн сангийн холбогдох стандартын шаардлагыг хангах;

4.3.2.төрийн болон бусад байгууллага тус бүр тоон мэдээ, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, мэдээллийн санд оруулах ажлыг холбогдох мэргэжилтэнд хариуцуулах;

4.3.3.мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах талаарх заавар, шаардлагыг мөрдөх;

4.3.4.мэдээллийн санг тогтмол шинэчлэх, баяжилт хийх, санд тоон мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд тухай бүр үнэн зөв оруулах;

4.3.5.онцлог тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох.

Тав.Бусад

5.1.Тоон мэдээ, мэдээллийг энэ журамд зааснаас бусад зорилгоор ашиглах, бусдад ашиглуулах, шилжүүлэхийг хориглоно.

5.2.Тоон мэдээ, мэдээлэл солилцох үйл ажиллагаанд цугларсан баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжид зааснаар хадгалж, шийдвэрлэнэ.

5.3.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---